

СОЁМБОМЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН 2021.07.10 №90 (90)

ЦЭРГИЙН ХҮРЭЭ, ХОТХОНЫ ЦЭРГИЙН ЦАГДААГИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ЧИГЛЭСЭН ҮҮРЭГ ӨГЛӨӨ

ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтсээс цэргийн хүрээ /хотхон/-ний цэргийн цагдаагийн нэгжийн дарга нартай өчигдөр цахимаар хуралдлаа. Хуралд Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлалын газрын дарга, хурандаа Д.Адъяабазар, ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтсийн дарга, дэд хурандаа Н.Лхагвасүрэн, мэргэжилтэн хошууч Б.Аваадорж нар оролцов. Энэ үеэр Замын-Үүдэд албан томилолтоор ажиллаж буй ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар холбогдож зарим үүргийг өгсөн юм.

Хурлын эхэнд “Цэргийн цагдаагийн ажиллагааны журам”, албаны шалгалтыг хэрхэн зохион байгуулах талаар сургалтыг явууллаа. Үргэлжлүүлээд удахгүй тохиох баяр амралтын өдрүүдэд ажиллахдаа анхаарах хэд хэдэн чиглэлийг өглөө.

Тухайлбал, Тулгар төрийн 2230, Их Монгол Улсын 815, Ардын хувьсгалын 100 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үргэлжилсэн амралтын өдрүүд болж байгаатай холбогдуулан сонор сэрэмжтэй байж цэргийн цагдаагийн эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэлтийг эрчимжүүлэхэд анхаарах, Цэргийн цагдаагийн нэгжүүд орон тооны дутуу байгаа бүрэлдэхүүнээ нэгтгэл, анги, байгууллагаас нөхөн хангаж мөн шаардлагатай үед цэргийн цагдаад дэмжлэг үзүүлэх алба хаагчдыг цэргийн хүрээ /хотхон/-ний нэгтгэл, ангийн бие бүрэлдэхүүнээс сонгож, томилгоожуулан 10-18-ны өдрүүдэд



2-оос доошгүй цэргийн алба хаагчийн бүрэлдэхүүнтэй эргүүлийг 24/48 цаг, 3 ээлжээр нэгтгэл, анги, байгууллагын байрлал, албан тушаалын байр, эрсдэл бүхий объект, голын эргийн дагуу томилон үүрэг гүйцэтгүүлэхээр болов. Үүрэг гүйцэтгэхдээ “Цэргийн цагдаагийн ажиллагааны журам”-ыг агштал мөрдөж ажиллахыг сануулав.

Түүнчлэн БХЯ, ЗХЖШ болон бусад газар хэлтсээс нэгтгэл, анги, салбаруудад хүргүүлсэн тушаал, заавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахад анхаарахыг үүрэг болголоо. Мөн аливаа үйл ажиллагааны өмнө холбогдох заавар, чиглэл, хязгаарлалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг цэргийн цагдаагийн бүрэлдэхүүнд урьдчилан

танилцуулан баталгаажуулахаас гадна Цэргийн цагдаагийн бүрэлдэхүүнийг цэргийн алба хаагч болон энгийн иргэдтэй харилцах харилцааны соёл, бие авч яваа байдалд ямагт зөв үлгэр дуурайлал үзүүлж, цаг үеийн байдлаас шалтгаалан үүсэж болзошгүй нөхцөл байдалд бэлэн байх зэрэг үүргийг өглөө.

ЦЭРГИЙН БАГТ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан НАТО-гийн “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд ХБНГУ-ын удирдлага дор Хойд бүсийн командлалд үүргээ амжилттай гүйцэтгэсэн дэд хурандаа Э.Амартүвшин захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн хамгаалалтын ротын 13 дугаар ээлжийн бие бүрэлдэхүүн Германаар дамжин эх орондоо буцав.

Цэргийн баг ХБНГУ-ын Ханновер хотод байх хугацаанд Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Ганбат тэргүүтэй төлөөлөгчид цэргийн сүүлчийн багийн бие бүрэлдэхүүнтэй уулзаж, хүндэтгэл үзүүлэв.

Монгол Улсын Зэвсэгт хүчин 2003-2021 онд Афганистанд олон улсын цэргийн ажиллагаанд оролцсон ба ХБНГУ-тай 2009 оноос хойш нийт 2600 гаруй цэргийн алба хаагч хамтран үүрэг гүйцэтгэсэн юм.

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
өдөр	шөнө
☀️ 27	🌙 11
ӨМӨНД СУДАН	
өдөр	шөнө
☀️ 32	🌙 22

ВАЛЮТЫН ХАНШ		
Валют	Авах	Зарах
USD 🇺🇸	2.851.00	2.853.00
EUR 🇪🇺	3.390.00	3.400.00
CNY 🇨🇳	441.00	442.00
RUB 🇷🇺	38.40	40.10
JPY 🇯🇵	25.36	25.84
KRW 🇰🇷	2.43	2.57

ЗУРХАЙ
АРГЫН ТООЛЛЫН:
2021.07.07
ЛХАГВА ГАРАГ

ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН УЛААН ЛУУ ӨДӨР

НАРАН УРГАХ ШИНГЭХ:
05.01-20.53

ҮС ЗАСУУЛБАЛ:
ХЭРҮҮЛ ТЭМЦЭЛ ИРНЭ

БАРИЛДЛАГА:
ИДЭР

ШҮТЭН БАРИЛДЛАГА:
НЭР ӨНГӨ

Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, хур оруулах, дархны үйлд сайн.

Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Бага халуун буух улирал (5 цаг 30 мин)-д эхэлнэ. Усны хор буух 7 хоног эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 126.811	ЭДГЭРСЭН 87.145	НАС БАРСАН 629/12
НИЙТ БАТЛАГДСАН 3580(60)	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 3454	ЭДГЭРСЭН 3164

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД
Тохиолдол Нийт: 183,788,043
Эдгэрсэн Нийт:
Нас барсан Нийт: 3,977,121





ТОКИО-2020 олимпад оролцох “Алдар” спорт хорооны тамирчдын танилцуулж байна

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫНХАА ДАРХЛААГ ДЭМЖИВ

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Коронавирусийн халдвар эрчимтэй тархаж байгаа энэ цаг үед Баянхонгор аймгийн засаг даргын тамгын газраас Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагчдад коронавирсийн халдвараас урьдчилан сэргийлэх болон эмчилгээний 10 хоногийн бараа материалыг хүлээлгэн өгөх арга хэмжээг зохион байгууллаа.

Энд норов-7, мана-4, аспири-100, өндөр тунтай витамин-С,Д т зэрэг тус бүр 20.000 төгрөгийн үнэ бүхий 80 ширхэг багц хүлээлгэн өглөө.

Хошууч Г.БАТ-ӨЛЗИЙ

ОЛОН ТӨРӨЛД АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН ТЭРГҮҮЛЭЭ

Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан “Дасгал, хөдөлгөөн хийцгээ” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяны хүрээнд Өвөрхангай аймгаас уралдаан тэмцээний хэлбэрээр зохион явууллаа. Унадаг дугуй, гүйлтийн төрөлд 4000 гаруй тамирчид амжилттай оролцож дүнгээ гаргалаа. Тэмцээний унадаг дугуйн төрөлд эхний гурван байранд ангийн үлээвэр найрал хөгжмийн салааны ахлах хөгжимчин, ахлах ахлагч В.Өлзий-Орших 2925 км, Танкийн батальоны цахилгаан холбооны бүлгийн дарга ахлагч Б.Жанчив 2538 км, холбооны албаны нярав, засварчин



Э.Наянжин 2382 км, гүйлтийн төрөлд холбооны албаны станцын дарга жолооч, ахлах ахлагч Б.Бямбахүрэл 777,7 км, механик жолооч, ахлагч

Д.Хэнмэдэхүй 739,9 км замыг туулсан үзүүлэлттэйгээр тус ангийн тамирчид аймгийн хэмжээнд тэргүүлээ.

Хошууч Л.АМАРБЯЭСГАЛАН

ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 234 ДҮГЭЭР АНГИД

Зэвсэгт хүчний 234 дүгээр анги



Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаалын дагуу түвшин тогтоох үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд офицер, ахлагч нараас биеийн тамирын шалгалт урьдчилсан байдлаар авч дүгнэлээ.

Тус үзлэгт бэлдэж “Цэргийн гавьяа”-ны одонт Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн офицер, ахлагч нар түвшин тогтоох үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд өглөө бүргүйж дасгал хөдөлгөөнийг спортоор хичээллэж байна.

Ч.ОЮУНЧИМЭГ

Дэлхий дахинд

БНХАУ дэлхийн тойрог зам дахь сансарын станц руу хүн илгээнэ

Доктор /Ph.D/, хурандаа Р.ЭНХБОЛД



Дэлхийн нам өндрийн тойрог замд хятадын байгуулж буй сансарын станц руу “Long March 2F” зөөгч пуужингаар 3 сансарын нисгэгчтэй “Shenzhou-12”

хөлөг жолоодлогот нислэг үйлдэх гэж байна. Сансарын хөлгийг БНХАУ-ын Өвөр Монголын нутагт байрлах “Jiuquan” сансарын буудлаас хөөргөх ба уг буудал

нь манай Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт байрлах Шивээхүрэн хилийн боомтоос баруун урд зүгт ойролцоогоор 200 км-ийн зайд байрладаг аж.

Түүнчлэн БНХАУ-ын Үндэсний сансар судлалын агентлаг нь сүүлийн 7 сарын хугацаанд гарамгай амжилт гаргаад байна. Тухайлбал хятадын сансарын хөлөг 2020 оны 12 дугаар сард Сарандээр, 2021 оны 5 дугаар сард Ангарга гариг дээр гардсан. Тэд дэлхийн нам өндрийн тойрогт “Тэнгэрийн ордон” нэртэй сансарын станц байгуулж байгаа ба уг станц нь 16,6 м урт, амьдрах эзлэхүүн нь 50 куб/м юм. 2022 оны 12 дугаар сараас уг станцад сансарын нисгэгч нар байнга ажиллахаар төлөвлөж байна.

/Эх сурвалж: bbc.com/

ОЛИМПИЙН ИХ НААДМЫН МӨНГӨН МЕДАЛЫТ МУГТ, ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, ГАВЬЯАТ ТАМИРЧИН, ДЭД ХУРАНДАА О. ГҮНДЭГМАА



Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат тамирчин, дэд хурандаа Отрядын Гүндэгмаа нь 1978 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн.

О.Гүндэгмаа 1984 онд Улаанбаатар хотын СХД-ийн Ерөнхий боловсролын 19 дугаар сургуульд элсэн орж 1994 онд төгссөн. Тэрээр 1998-2002 онд Үндэсний биеийн тамирын дээд сургуулийг багш дасгалжуулагч мэргэжлээр, 2004-2008 онд Монгол Улсын Их Сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр тус тус суралцан төгссөн.

О.Гүндэгмаа 1993 оноос буудлагын спортоор хичээллэж 1995 оноос

буудлага спортын шигшээ багийн тамирчин, 1998 оноос эхлэн Зэвсэгт Хүчний Алдар спорт хороонд Их спортын техник хэрэгслийн албаны даргаар ажиллаж байна.

Тэрээр хүн төрөлхтний баяр цэнгэл Олимпын их наадамд тасралтгүй 7 удаа дараалан оролцож байгаа Монгол улсын анхны тамирчин юм. Мөн түүний хань Монгол улсын Хөдөлмөрийн

Монгол улсын хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин О. Гүндэгмаа буудлага спортоор гаргасан амжилт, хөдөлмөр зүтгэлийг өндрөөр үнэлж Батлан хамгаалах яамны “Хүндэт тэмдэг”, Батлан хамгаалах яамны “Тэргүүний ажилтан”, Биеийн тамир спортын газрын “Тэргүүний ажилтан”, Эрүүл мэндийн “Тэргүүний ажилтан”, Засгийн газрын “Хүндэт жуух



баатар, Гавьяат тамирчин Хашбаатарын Цагаанбаатар Монголын жүдо бөхийн анхны Дэлхийн аварга, гэр бүлийн хоёр хоёулаа Монгол улсын хөдөлмөрийн баатар ховорхон хувь заяа юм.

бичиг”, Нийслэлийн “Тэргүүний залуу”, “Алтан гадас одон”, “Монгол улсын гавьяат тамирчин”, Нийслэлийн “Хангарьд одон”, “Сүхбаатарын одон”, “Монгол улсын хөдөлмөрийн баатар” цолоор тус тус шагнагдсан.

2021 ОНЫ ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ЭХЭЛЛЭЭ

Зэвсэгт хүчний тээврийн хяналтын алба



Батлан хамгаалах салбарын тээврийн хэрэгслийн 2021 оны тооллого техникийн хяналтын улсын үзлэг шалгалт ЗХЖШ-н даргын 2021 оны А/316 дугаар тушаалын дагуу

2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Зэвсэгт хүчний 310 дугаар ангиас эхэллээ. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбар, байгууллагууд тээврийн хэрэгслийн тооллого

техникийн хяналтын улсын үзлэгт бэлтгэх зөвлөмжийн дагуу үзлэг шалгалтдаа бэлтгэн оролцохыг зөвлөж байна.

Ахлах дэслэгч Д.ГАНХУЯГ

Цаг үе

Эмч, ажилтнуудын цалинг хоёр дахин нэмэх тохиролцоонд хүрчээ

Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын үндсэн цалинг хоёр дахин нэмэгдүүлэх түр хороо ЭМЯ-тай тохиролцоонд хүрч, салбарын нэмэлт хэлэлцээрийг өчигдөр байгууллаа. Энэ үеэр эмч, ажилтнуудыг эрүүл мэнд, амь нас, эрсдэлийн даатгалд хамруулах талаар зөвшилцөлд хүрч цаашид хамтран ажиллаж даруй шийдэхээр болсон байна. Түүнчлэн Монголын эрүүл мэндийн салбарынхан бүхэлдээ улаан бүс болсон тул улаан, ногоон бүсээр ялгаварлахгүй цалинг хоёр дахин нэмэх тохиролцоонд хүрч, талууд хэлэлцээрт гарын үзэг зуржээ.

Энэ тухай Эрүүл мэндийн сайд С.Энхболд, “Эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний холбоотой ЭМЯ уулзалт зохион байгуулж, эрүүл мэндийн салбарын хөдөлмөр,



нийгмийн зөвшилцлийн гурван талт хамтын хэлэлцээрийг амжилттай зохион байгуулж гэрээгээ баталгаажууллаа. Эхлүүлсэн ажлаа хамтдаа дуусгана. Бид нэг салбарынхан. Ойлголцох ёстой. Цаашид ч гэсэн ойлголцож хамтран ажиллах болно

гэдэгтэй итгэлтэй байна” гэжээ. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын үндсэн цалингийн төсвийн эх үүсвэрийг улсын төсөвт суулгах эсэхийг УИХ-ын Төсвийн байнгын хороо, УИХ-ын Нийгмийн Бодлогын Байнгын Хороо УИХ болон Засгийн газар шийдэх аж.